



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2025 оны I улирал

ИХ САНАСАН ГАЗАР ЕСӨН ШӨН Ө ХООСОН

ИХ САНАСАН ГАЗАР ЕСӨН ШӨНӨ ХООСОН

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 хувиар нэмэгдлээ. Эдийн засгийн салбаруудын сэргэлттэй зэрэгцэн чанаргүй зээлийн хэмжээ буурч эхэлжээ. Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн банкны зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Төлбөрийн тэнцэл алдагдалтай байхад нэг талаас импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэж байгаа, нөгөө талаас экспортын орлого төсөөлснөөс доогуур байгаа нь нөлөөлж байна. Ийнхүү экспортын орлого тасрах нь төгрөгийн худалдан авах чадвар муудгаж тэр хэмжээгээр валютын нөөцөд дарамт болох эрсдэлийг дагуулж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт огцом буурсан нь төсвийн орлогыг бууруулж, төсвийн тэнцэл алдагдалтай байх нөхцөлийг бүрдүүллээ.

Хөдөө аж ахуйн салбар болон барилга, боловсруулах үйлдвэрийн салбар сэргэж эхэлсэн нь эдийн засаг 2.4 хувиар тэлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Уул уурхай салбар хүлээлтээс бага өсөлттэй байсан нь түүнийг дагасан тээвэр логистик, агуулах, худалдааны салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлж эдийн засгийн өсөлтийг удаашрууллаа. Нийлүүлэлтийн гаралтай бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэмэгдсэн нь инфляцын түвшин нэмэгдэхэд нөлөөлжээ.

Өнгөрсөн оны төгсгөлд ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлт тогтвортой байж, экспортын орлогоос олох орлогыг хэт өөдрөг төсөөлж түүн дээр тулгуурлан урсгал зардлыг хэт ихээр тэлсэн, томоохон төслүүдийг эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлэхгүйгээр шууд эхлүүлэх ажлуудыг хийсэн. Одоогийн эдийн засгийн нөхцөл байдлыг харахад эдгээр тооцоо судалгаагүй хэт үрэлгэн байдал нь “Их санасан газар есөн шөнө хоосон” байхын үлгэр мэт болжээ.



Хэдийн хэрэглээний зээлийн шаардлагыг нэмэгдүүлсэн ч хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна

Цалин, тэтгэврийн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 хувиар нэмэгджээ.
Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан 26 хувиар нэмэгджээ.



Онолын
тодорхойлолт



Банкны шинээр олгосон
зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг

Иргэдийн зээл олголт, жил бүрийн I улирал

Их наяд ₮



Иргэдийн зээл
22%
Нэмэгджээ.



2025 оны I
улирлын
гүйцэтгэл

2025 ОНЫ БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Иргэд, аж ахуйн нэгжийг дэмжихэд чиглэсэн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.



Банкуудын чанаргүй зээлийн багц буурчээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Олон нийтэд нээлттэй болсон банкууд 2023 оны ашгаас 483 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний ногдол ашиг хуваарилжээ.



Банкны салбарын өрсөлдөх чадвар сайжирсан хэдий ч цаашид улам бүр нэмэгдүүлэх ажлууд олон байна.



Төгрөгт итгэх итгэл хэвээр байгаа нь төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд нөлөөлжээ.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 он I улирал

Эдийн засгийг дэмжихэд чиглэсэн зээлийн өсөлт үргэлжилж байна.

Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.
Иргэдийн зээлийн шаардлагыг нэмэгдүүлсэн нь иргэдэд олгох зээлийн өсөлтийн хурдыг сааруулав.


Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+33%

Зээлийн үлдэгдэл өсөв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо




Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн зээл олголт нэмэгджээ.

Уул уурхай болон боловсруулах салбарт олгож буй зээлийн хэмжээ буурчээ.

Барилга, худалдаа, үйлчилгээ болон ХАА-н бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн зээлийн хэмжээ огцом нэмэгджээ.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн I улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг

Шинээр олгосон зээл

30%

өсжээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээлийн хэмжээ
буурчээ.

5.2%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Зээлийн багцын чанар сайн байна.

Авто машины зээлийн чанаргүйдэл бусад хэрэглээний зээлтэй харьцуулахад өндөр байна.
Эдийн засаг сэргэж байгаа нь бизнесийн зээлийн чанар сайжрахад эергээр нөлөөлж байна.
Бизнесийн 10 зээл тутмын 1 нь чанаргүй байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Зээлийн хүү

17%

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү тогтвортой байна.

Гадаад эдийн засгийн нөлөө, төсвийн хэт тэлэлтээс үүдэлтэйгээр эдийн засагт хэлбэлзэл үүсэхээс сэргийлж бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь зээлийн хүү нэмэгдэх хүлээлтийг буй болгоод байна.



Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч төгрөгт итгэх итгэл нэмэгдсэн нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад валютын харилцах 15 хувиар буурчээ.
Иргэд валютын харилцахыг валютын хадгаламж руу хөрвүүлж байна.
Төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж эерэг байгаа нь иргэдийн төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд нөлөөллөө.

Банкны эх үүсвэр, жил бүрийн I улиралд

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

22%

НЭМЭГДЭВ

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 он I улирал

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив өсөв.

27%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан


Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 13.6 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Банкны салбарын активын өсөлт үргэлжилсээр байна.

Голомт банкны актив 49 хувиар, ХХБ актив 27 хувиар, Хас банкны актив 25 хувиар тус тус өсжээ.

Банкуудын актив жил бүрийн I улирал


Их наяд ₮



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Төрийн банкны эх үүсвэр 23 хувиар, Хас банкны эх үүсвэр 18 хувиар, Голомт банкны эх үүсвэр 13 хувиар тус тус нэмэгджээ. Бусад банкны эх үүсвэрийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкуудын эх үүсвэр жил бүрийн I улирал



2023	2024	2025
Хаан		
2023	2024	2025
ХХБ		
2023	2024	2025
Голомт		
2023	2024	2025
Төрийн банк		
2023	2024	2025
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкнүүдын эх үүсвэр нэмэгдэв.

12%

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс
гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний
өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг
хэлдэг.

Банкуудын өөрийн
хөрөнгийн хүрэлцээний
дундаж

17%


Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байна.

Банкууд эдийн засгийн салбаруудыг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкууд өөрийн ашгаас 1.1 их наяд төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилжээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн I улирал




2023	2024	2025
Хаан	ХХБ	Голомт
2023	2024	2025
Төрийн банк	Хас	

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Банкуудын олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна.
Банкнудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт буурсан хэдий ч хангалттай хэмжээний хөрвөх чадвартай байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн I улирал



2023	2024	2025
Хаан		
2023	2024	2025
ХХБ		
2023	2024	2025
Голомт		
2023	2024	2025
Төрийн банк		
2023	2024	2025
Хас		

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

37%

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2025 оны I улирал: Эдийн засгийн өсөлт 2.4 хувьтай гарлаа. Хөдөө аж ахуйн салбар болон боловсруулах, барилгын салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүллээ. Гадаад эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан уул уурхайн салбарын өсөлт нь хүлээлтээс харьцангуй доогуур байснаас үүдэлтэйгээр уул уурхай дагасан тээвэр, логистик болон худалдаа үйлчилгээний салбар удааширч эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын түвшин өндөр байна.


Төлөв байдал: Эдийн засгийн үзүүлэлтүүд төсөөллөөс харьцангуй муу байна. Учир нь уул уурхайн гол бүтээгдэхүүн болон нүүрс болон цайрын хүдэр, баяжмалын дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан нь экспортын орлого буурах, валютын орох урсгал тасалдах эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн, эдийн засгийн томоохон төслүүдийг эхлүүлэхтэй зэрэгцэн импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэж буй нь валютын гарах урсгалыг нэмэгдүүлж, валютын нөөцөд дарамт учруулах төлөвтэй байна.

2025 оны эхний улиралд эдийн засаг 2.4 хувиар өсөв.

Хөдөө аж ахуйн болон аж үйлдвэр, барилгын салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтийг түлхүү дэмжлээ.

Уул уурхайн салбар нь хүлээлтээс доогуур өсөлттэй байлаа. Үүнийг дагаад тус салбараас хамааралтай тээвэр логистик, худалдааны салбар агшжээ.

Үйлчилгээний салбар өсөлттэй байна.




Гадаад худалдааны тэнцэл эхний улиралд 1.2 тэрбум ам.долларын ашигтай байна.

Нүүрсний биет хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад ойролцоо түвшинд байгаа хэдий ч дэлхийн зах зээлд дээрх үнэ буурсан нь экспортын хэмжээ үнийн дүнгээр буурахад нөлөөлжээ.

Зэсийн олборлолт нэмэгдсэн нь зэсийн баяжмалаас олох орлогыг нэмэгдүүлжээ.

Импортын бараа, тэр дундаа хөрөнгө оруулалт болон нефтийн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн нь импортын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ


Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн бууралт нь **экспортын өсөлтийг** саарахад нөлөөлжээ.



Хөрөнгө оруулалтын болон нефтийн бүтээгдэхүүний өсөлт нь **импортын хэмжээг нэмэгдэхэд** нөлөөлжээ.




Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан хэдий ч **худалдааны тэнцэл ашигтай** байна.




Төлбөрийн тэнцэл 613 сая ам.долларын алдагдалтай байна.

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь санхүүгийн дансны ашиг нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлжээ.
- Импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдсэн нь урсгал данс алдагдалтай гарахад нөлөөлжээ. Нөгөө талаас уул уурхайгаас олох орлогын хэмжээ буурсан нь валютын орох урсгалыг бууруулжээ.
- Төгрөгийн бодит ханш суларч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад хямдхан болж эхэлжээ.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш




Төлбөрийн тэнцэл алдагдалтай байна.



Инфляц аажмаар нэмэгдэж байгаа нь хадгаламжийн бодит өгөөж буурахад нөлөөлж байна.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин огцом нэмэгдсэн нь хадгаламжийн бодит өгөөжийг бууруулжээ. Төгрөгт итгэх итгэл хэвээр байгаа тул төгрөгийн хадгаламжийн өсөлтөд эергээр нөлөөлжээ.



Төсвийн тэнцэл 353 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.


Түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт буурсан нь төсвийн орлого огцом буурахад нөлөөллөө.

Төсвийн урсгал зардал, тэр дундаа цалин, хөлсний зардал нэмэгдсэн нь төсвийн зардлын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.


Үндсэн тэнцэл ашигтай байгаа ч төсвийн алдагдлын дарамт нэмэгдэж байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурчээ.

ДНБ-д эзлэх хувиар



Нийт төсвийн зарлага өмнөх оны мөн үеэс 14 хувиар нэмэгджээ.



Төсвийн алдагдал нэмэгдэж байна.



Монгол Улс банкны салбарын өрсөлдөх чадвар сайжирсан хэдий ч макро эдийн засгийн хүчин зүйлсээс хэт хамааралтай байна.

Банкны салбар нь цар тахлын болон цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Нөгөө талаас өнгөрсөн 4 жилийн хугацаанд банкны салбарт хийгдсэн хууль, эрх зүйн өөрчлөлтүүд болон дижитал шилжилт нь банкны салбарын өрсөлдөх чадварт эергээр нөлөөлжээ.


Банкны өрсөлдөх чадвар ямар түвшинд байна?

2024 оны өрсөлдөх чадварын судалгаагаар
түүвэрт сонгогдсон 37 улсаас

**“Монгол Улс 9-р байранд
жагсаж 18 байран
урагшилсан байна.”**

Банкны салбар нь цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн. Нөгөө талаас банкны салбарт хийгдсэн хууль, эрх зүйн өөрчлөлтүүд болон дижитал шилжилт нь банкны салбарын өрсөлдөх чадварт эергээр нөлөөлжээ.

Банкны салбарын үзүүлэлтүүд



Өрсөлдөх чадварын индексээр бүс нутагтаа тэргүүлж байна.



Сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ эрчимтэй нэмэгдэхийн хэрээр тухайн бүс нутгийн банкны салбарын ашигт ажиллагаа болон хүртээмж нэмэгдэж буй нь харагдаж байна.

Өрсөлдөх чадварын индексэд ямар хүчин зүйлс эергээр нөлөөлөв

Хүртээмжийн индексээр 2-т

Нэг хүнд ногдох АТМ болон банкны салбарын үзүүлэлт сайн. Мөн банканд данстай иргэдийн тоогоор дэлхийн хөгжингүй улсуудтай ижил түвшинд байна.

Мэдээлэл технологийн индексээр 2-т


Нийт хүн амд эзлэх ухаалаг гар утас эзэмшигчдийн тоо болон интернэт хэрэглэгчдийн тоогоор тэргүүлж байна.

Хүн амын хөгжлийн индексээр 10-т


Нэг хүнд оногдох ҮНО-ийн индекс тасралтгүй нэмэгдэж байна

Хүн амын дундаж наслалт өсөлтийн трендтэй байна
Харин хүн амын боловсролын түвшин буурчээ.

Ирэх жилүүдэд гадаад өрийн дарамт бага буй хэдий ч банкны салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.



Авлигын индекс буурахгүй, бизнесийн хийх орчин бүрдэхгүй байгаа нь банкны салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.



Банкны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд цаашид анхаарах зүйлс

Банкны гүнзгийрлийг нэмэгдүүлэх

ЖДҮҮ эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах. Эдгээр байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллах.

Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх

Бизнес эрхлэхэд таатай хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх. Дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарах.

Макро тогтвортой байдлыг хангах.

Засгийн газрын хэрэглээг багасгах. Эдийн засгийн хүчин зүйлсийг (инфляц, ханш гэх мэт) тогтвортой байлгахад анхаарал хандуулах.